



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 31

Мандалговь

Г  
Б.Энхжаргалыг Татварын хэлтсийн Адаацаг  
сумын татварын улсын байцаагчийн  
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Татварын хэлтсийн Адаацаг сумын татварын улсын байцаагчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Баянмөнх овогтой Энхжаргал 60.8 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Энхжаргалын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



**Татварын хэлтсийн Адаацаг сумын Татварын  
улсын байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Б.Энхжаргалын тухай дүгнэлт**

1. Б.Энхжаргал нь 1990 онд Дундговь аймгийн Адаацаг суманд төрсөн. 32 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2017-2021 онд Орхон их сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2012-2014 онд Адаацаг сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч, 2014-2015 онд ЕБС-ийн нягтлан бодогч, 2015-2021 онд Адаацаг сумын ЗДТГ-ын нягтлан бодогчоор ажиллаж байсан.
4. Б.Энхжаргалын төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Татварын хэлтсийн Адаацаг сумын Татварын улсын байцаагчийн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

